

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/29/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Дорноговь аймаг)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734, Цахим хаяг: dornogovi@audit.gov.com

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Аудитор: Э.Вандандулам

Утас: 99058176 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
	Бараа материалын ангилал, бүртгэл, тайлагналын асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
	1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ	12
	ӨМНӨХ АУДИТ БОЛОН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, ҮР ДҮН	13
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	0
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	0

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайшанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.ГАНБААТАР**

2019-02-20 № 16/99
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

9825888

Аудитын гол асуудал:

1. Тайлант онд түлш халаалтын зардалд батлагдсан 63,991,800 төгрөгийн зарцуулалтыг хийхдээ төрийн болон орон нутгийн өмчөөр бүтээгдэхүүн ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, www.tender.gov.mn сайтад байршуулж нийтэд мэдээлээгүй, нээлттэй тендер зарлаагүй, шууд худалдан авалтыг Б.Магсармаа, Р.Эрдэнэболд, Г.Мөнхдөл, Ди Ай Би Би Эй ХХК зэрэг хувь хүн, байгууллагатай гэрээ байгуулж хийсэн. Бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээг дүгнээгүй, шалтгаан тодорхой бус байхад дараагийн бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулахдаа тендер зарлаагүй ажилласан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 заалт, Сангийн сайдын 2013-01-11-ний өдрийн 1-р тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоолыг зөрчиж уг худалдан авалтад оролцох иргэд байгууллагын боломжийг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил үүссэн байх нөхцөлийг бүрдүүлсэн байж болзошгүй байна.
2. Мөн тайлант хугацааны хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд батлагдсан 17,650,000 төгрөгийн худалдан авалтыг хийхдээ харьцуулалтын аргыг хэрэглээгүй олон бэлтгэн нийлүүлэгчээс шууд худалдан авалтыг хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 заалт, Сангийн сайдын 2013-01-11-ний өдрийн 1-р тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоолыг зөрчиж харьцуулах боломжгүй байх нөхцөлийг үүсгэж, төсвийн хөрөнгийг хэмнэлттүй зарцуулах эрсдэлийг үүсгэсэн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Ганбаатар-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-01-20-наас 2019-01-25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-02-02-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019-01-29-ны өдрийн 03 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль нь Эх оронч сэтгэлгээ төлөвшүүлэх, хүмүүнлэг энэрэнгүй ёсонд суралцах, авьяас чадвараа нээн хөгжүүлэх, сурах арга барилд тасралтгүй суралцах, амьдрал хөдөлмөрт өөрийгөө бэлтгэхэд туслахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмээр Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.
2. Ерөнхий боловсролын үйлчилгээ
3. Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 (нэг) хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны нийт зардал нь 469696,7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4696,96 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь 4696,96 мянган төгрөгөөс доош дүнгээр гарсан ажил гүйлгээ нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	280.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	81641.8	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	81921.8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

1. Тайлант онд түлш халаалтын зардалд батлагдсан 63,991,800 төгрөгийн зарцуулалтыг хийхдээ төрийн болон орон нутгийн өмчөөр бүтээгдэхүүн ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, www.tender.gov.mn сайтад байршуулж нийтэд мэдээлээгүй, нээлттэй тендер зарлаагүй, шууд худалдан авалтыг хийсэн, мөн тайлант хугацааны хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд батлагдсан 17,650,000 төгрөгийн худалдан авалтыг хийхдээ харьцуулалтын аргыг хэрэглээгүй олон бэлтгэн нийлүүлэгчээс шууд худалдан авалтыг хийсэн зэрэг зөрчил илэрсэн. Ихэнх худалдан авалт нь Сангийн сайдын 2017-12-05-ны 347 тоот тушаалаар батлагдсан НХМ-ТМ-5-аар гүйлгээ хийгдэхгүй байгаа тул худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу гэж үзлээ.

Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан тухай хууль, Сангийн сайдын 2013-01-11-ний өдрийн 1-р тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журмыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгч, биелэлтийг 2019 оны 12-р сарын 25-ний дотор Дорноговь аймгийн Төрийн аудитын байгууллагад ирүүлэх

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Бараа материалын ангилал, бүртгэл, тайлагналын асуудал

Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, тооллого

2.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 429839.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 427256,5 мянган төгрөг буюу 99.4% хувьтай байгаа нь Урсгал санхүүжилтийн орлогоос 2574,5 мянган төгрөгийг хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүний 1676,4 мянган төгрөг нь төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж, 530,8 мянган төгрөг нь хангамж, бараа материалын зардал, 312,9 мянган төгрөг нь цалин, тогтмол зардал зэргээс хэмнэснээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар Өмнөх оны аудитаар өгсөн ХЧТАТ-ээс ХХОАТ суутгахгүй байх, туслах үйл ажиллагааны ажилчидтай гэрээ байгуулж, орлого зардлыг тооцож бүртгэлд тусгаж байх зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Зөвлөмжийн хэрэгжилт 33% хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 САНАЛ ДүГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

1. Цалингийн тооцоолол нь эмх замбараагүй, цалин, ХХОАТ-ыг илүү дутуу бодох үйлдэл хийснээс тодорхойгүй суутгал хийх, нэмэгдэл олгосон нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10, 20.2.13 –ийн заалтыг зөрчиж байна.
2. ХЧТАТ-ээс ХХОАТ-ыг тооцож суутгасан нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 29.4-р заалт, ХХОАТ-ын 16.1.1-р заалтыг тус тус зөрчиж байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг илүү зарцуулах, ажилчид өөрийн гар дээр авах цалинг хянахад эргэлзээ төрүүлэх, хянах боломжийг алдагдуулах, ажилчдын цалинг дутуу олгох

Зөвлөмж

Цалинг санхүүгийн программ ашиглаж бодох, нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар хянамгай байдлаа сайжруулж ажиллах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Ганбаатар

Төсвийн захирагчийн хариу

Татварын албанаас тавьж буй шаардлагын дагуу ХЧТАТ-ээс ХХОАТ тооцсон.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

ӨМНӨХ АУДИТ БОЛОН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

Илрүүлэлт

1. Тайлант хугацааны туслах үйл ажиллагааны орлогод нас дэвшилт төл малын орлого бүртгэгдсэн хэдий ч малаас хүлээн авсан бүтээгдэхүүний орлого, түүний зарцуулалтыг бүртгээгүй сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.6, 7.1, 7.2, 7.3 заалт, төсвийн тухай хуулийн 44.5, 44.7-р заалтуудыг зөрчиж байна.
2. Тайлант хугацаанд төгсөгчдийн хандивласан хөрөнгийг хүлээн авахдаа анхан шатны баримтад хүлээлгэн өгсөн, хүлээн авсан гарын үсэг зураагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 заалт, төсвийн тухай хуулийн 25.7 заалт, УСНББОУС 23-ийн 93-108 хэсгийг зөрчсөн байна.

Эрсдэл

Төсөвт байгууллагын хөрөнгө, нэмэлт орлогыг дутуу бүртгэх

Зөвлөмж

Туслах үйл ажиллагааны үйл ажиллагааны орлогыг тодорхойлж бүртгэн санхүүгийн тайланд тусгаж, зарцуулалтыг холбогдох дүрэм журмын дагуу хийж байх, ажилчидтай гэрээ байгуулж ажиллах. Төгсөгч, эцэг эхчүүд, бусад холбоотой талаас хандивласан хөрөнгийг холбогдох стандарт, хууль, дүрэм журмыг баримтлан бүртгэж, санхүүгийн тайланд тусгаж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Ганбаатар

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудалын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6-р сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Э.ВАНДАНДУЛАМ

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,160,039.67	74,512,754.56
33	АВЛАГА	7,969,205.00	150,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,969,205.00	00.00
335	Бусад авлага	00.00	150,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,190,834.67	74,362,754.56
351	Түүхий эд материал	82,300.00	161,400.00
35130	Эм боох материал	82,300.00	161,400.00
354	Хангамжийн материал	66,468,534.67	72,141,354.56
35410	Бичиг хэргийн материал	2,458,900.00	1,957,020.00
35420	Аж ахуйн материал	45,675,974.67	47,374,119.56
35440	Түлш, шатах тослох материал	11,935,200.00	15,096,200.00
35460	Хүнсний материал	4,259,910.00	6,268,265.00
35470	Бусад хангамжийн материал	2,138,550.00	1,445,750.00
35600	Мал амьтад	2,640,000.00	2,060,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	367,675,964.17	529,590,597.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	367,675,964.17	529,590,597.98
392	Биет хөрөнгө	367,675,964.17	497,564,597.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	492,324,384.00	330,205,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-290,384,812.43	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,674,336.00	-6,427,212.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	123,045,003.11	142,077,353.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,133,705.71	-62,225,392.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,111,970.40	59,138,970.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,506,386.12	-27,183,811.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,968,277.30	55,156,677.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,708,354.58	-25,184,792.46
39217	Ном	12,105,164.20	14,478,445.86
393	Биет бус хөрөнгө	00.00	32,026,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	32,026,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	444,836,003.84	604,103,352.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,986,240.00	170,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,986,240.00	170,000.00
413	Өглөг	1,986,240.00	170,000.00
4136	Бусад өглөг	33,240.00	170,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	170,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	33,240.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	442,849,763.84	603,933,352.54
51	Засгийн газрын хувь оролцоо	442,849,763.84	603,933,352.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	340,523,179.90	372,549,179.90
51101	Өмч: - төрийн	340,523,179.90	372,549,179.90
512	Хуримтлагдсан үр дүн	-50,815,532.56	-79,098,989.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-28,283,456.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	153,142,116.50	310,483,162.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	444,836,003.84	604,103,352.54

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	253,255,400.00	438,981,581.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,591,900.00	7,542,581.66
120	Нийтлэг татварын бус орлого	4,591,900.00	7,542,581.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,591,900.00	7,542,581.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	820,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,591,900.00	6,722,581.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	1,608,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	248,663,500.00	429,831,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,608,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,458,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	150,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	214,849,180.84	460,987,811.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,849,180.84	460,987,811.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,997,640.84	438,920,483.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,169,117.00	254,694,268.00
210101	Үндсэн цалин	78,737,768.00	166,590,555.00
210102	Нэмэгдэл	34,385,627.00	51,831,113.00
210104	Урамшуулал	10,917,722.00	24,869,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,128,000.00	11,403,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,560,358.00	31,284,106.00
210201	Тэтгэврийн даатгал	11,445,484.00	21,429,595.00
210202	Тэтгэмжийн даатгал	822,975.00	2,277,002.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,028,717.00	2,254,826.00
210204	Ажилгүйдлийн даатгал	205,743.00	503,625.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,057,439.00	4,819,058.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,763,354.00	67,084,129.00
210301	Гэрэл, цахилгаан	1,658,354.00	5,092,147.00
210302	Түлш, халаалт	24,649,900.00	61,256,982.00
210303	Цэвэр, бохир ус	455,100.00	735,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,113,370.00	11,941,045.11
210401	Бичиг хэрэг	821,570.00	1,903,730.00
210402	Тээвэр, шатахуун	1,172,970.00	1,150,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	20,350.00
210404	Ном, хэвлэл	37,650.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	245,500.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,219,000.00	8,616,295.11
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	616,680.00	00.00
2105	Нормативт зардал	13,661,304.00	24,299,419.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,250.00	280,850.00
210502	Хоол, хүнс	13,529,054.00	24,018,569.00
2107	Томилолт, зочны зардал	12,000.00	483,000.00
210702	Дотоод албан томилолт	12,000.00	483,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	679,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	679,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,718,137.84	48,454,766.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	170,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	88,000.00	1,458,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,630,137.84	46,826,766.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,851,540.00	22,067,328.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,851,540.00	19,342,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,851,540.00	16,105,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	3,237,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,574,528.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,574,528.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	150,000.00

Дэлгэрэх ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>38,406,219.16</u>	<u>-22,006,229.77</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	6,277,227.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,013,726.68
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,050,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	4,213,500.48
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-6,277,227.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>38,406,219.16</u>	<u>-28,283,456.93</u>

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	248,663,500.00	431,639,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	350,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	350,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,663,500.00	431,289,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	248,663,500.00	429,831,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,458,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,458,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	181,316,318.00	413,760,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	181,316,318.00	413,760,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	173,464,778.00	391,692,672.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,025,792.00	248,382,269.00
210101	Үндсэн цалин	81,410,373.00	160,278,556.00
210102	Нэмэгдэл	24,569,692.00	51,831,113.00
210104	Урамшуулал	10,917,727.00	24,869,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,128,000.00	11,403,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,315,902.00	31,579,900.00
210201	Тэтгэврийн даатгал	7,201,028.00	21,181,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	822,975.00	2,599,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,028,717.00	2,079,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	205,743.00	519,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,057,439.00	5,199,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,663,454.00	69,814,909.00
210301	Гэрэл, цахилгаан	1,658,354.00	5,092,147.00
210302	Түлш, халаалт	22,550,000.00	63,987,762.00
210303	Цэвэр, бохир ус	455,100.00	735,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,291,310.00	3,303,470.00
210401	Бичиг хэрэг	53,910.00	299,950.00
210402	Тээвэр, шатахуун	643,750.00	1,597,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	75,850.00
210404	Ном, хэвлэл	99,750.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	245,500.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	248,400.00	1,079,940.00
2105	Нормативт зардал	11,676,320.00	28,949,374.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,100.00	359,950.00
210502	Хоол, хүнс	11,590,220.00	26,026,924.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,000.00	2,562,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	4,793,800.00
210604	Урсгал засвар	00.00	4,793,800.00
2107	Томилолт, зочны зардал	12,000.00	483,000.00
210702	Дотоод албан томилолт	12,000.00	483,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	739,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	739,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,000.00	3,646,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,000.00	528,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,000.00	3,118,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,851,540.00	22,067,328.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,851,540.00	19,342,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,851,540.00	16,105,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	3,237,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,574,528.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,574,528.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	150,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	150,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	67,347,182.00	17,879,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	240,000.00	17,879,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	240,000.00	17,879,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	240,000.00	17,879,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	240,000.00	17,879,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-240,000.00	-17,879,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	67,107,182.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,107,182.00	00.00

4.6 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	340,523,179.90	153,142,116.50	-175,570,636.05	00.00	318,094,660.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	340,523,179.90	153,142,116.50	-175,570,636.05	00.00	318,094,660.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	38,406,219.16	00.00	38,406,219.16
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	340,523,179.90	153,142,116.50	-50,815,532.56	00.00	442,849,763.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	340,523,179.90	153,142,116.50	-50,815,532.56	00.00	442,849,763.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	157,341,045.63	00.00	00.00	157,341,045.63
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	32,026,000.00	00.00	-27,963,456.93	00.00	4,062,543.07
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	-78,778,989.49	00.00	604,253,352.54

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,831,000.00	427,256,472.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,831,000.00	427,256,472.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,811,800.00	407,913,672.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,566,200.00	248,382,269.00
210101	Үндсэн цалин	160,435,200.00	160,278,556.00
210102	Нэмэгдэл	51,858,400.00	51,831,113.00
210104	Урамшуулал	24,869,600.00	24,869,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,403,000.00	11,403,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,579,900.00	31,579,900.00
210201	Тэтгэврийн даатгал	21,181,200.00	21,181,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,599,600.00	2,599,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,079,700.00	2,079,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,900.00	519,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,199,500.00	5,199,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,943,900.00	69,814,909.00
210301	Гэрэл, цахилгаан	5,217,100.00	5,092,147.00
210302	Түлш, халаалт	63,991,800.00	63,987,762.00
210303	Цэвэр, бохир ус	735,000.00	735,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,023,300.00	3,492,470.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	299,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	1,597,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,000.00	75,850.00
210404	Ном, хэвлэл	406,000.00	389,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	891,300.00	879,940.00
2105	Нормативт зардал	28,957,200.00	28,949,374.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,000.00	359,950.00
210502	Хоол, хүнс	26,027,200.00	26,026,924.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,570,000.00	2,562,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,309,800.00	6,293,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	4,809,800.00	4,793,800.00
2107	Томилолт, зочны зардал	492,300.00	483,000.00
210702	Дотоод албан томилолт	492,300.00	483,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760,000.00	739,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760,000.00	739,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18179200.00	18178200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	529,200.00	528,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,650,000.00	17,650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21019200.00	19342800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,019,200.00	19,342,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,782,200.00	16,105,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,000.00	3,237,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	429,831,000.00	429,831,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	429,831,000.00	429,831,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	429,831,000.00	429,831,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31.00	31.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00